



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2003 оны 10 сарын 7 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

ДҮРЭМ, БҮТЭЦ ОРОН ТООГ БАТЛАХ  
ТУХАЙ

Монгол Улсын "Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удидлагын тухай" хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалт, 28 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2003 оны 272 дугаар захирамжийн 4 дэхь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Нийслэлийн Орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх ажлыг хэрэгжүүлэх үүрэг бүхий "Амьдрах ухаан-сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв" /Тэнэмэл амьдралтай иргэдийн түр хоноглох байртай/-ийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

Хоёр. "Амьдрах ухаан-сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв" /Тэнэмэл амьдралтай иргэдийн түр хоноглох байртай/-ийн орон тооны хязгаарыг 20 хүртэл байхаар тогтоож зохион байгуулалтын бүтцийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Батлагдсан орон тооны хязгаарт багтаан, ажлын шаардлагыг харгалзан албан хаагчдыг томилох, цалин нэмэгдлийг зохих журмын дагуу тогтоох, байгууллагын үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө, дотоод журам, ажилчин албан хаагчдын албан тушаалын зааврыг боловсруулан мөрдөх, ажлыг зохион байгуулахыг "Амьдрах ухаан-сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв" /Д.Эрдэнэтунгалаг/-д даалгасугай.

Дөрөв. Шинээр байгуулагдсан "Амьдрах ухаан сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв" –ийн 2003 оны 4 дүгээр улирлын төсвийг зохих журмын дагуу хянаж санхүүжүүлэхийг Санхүү эдийн засаг, төрийн сангийн хэлтэс /Д.Ганболд/-т даалгасугай.

Тав. "Амьдрах ухаан-сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв"-ийн ажил, үйлчилгээний онцлогийг харгалзан Засгийн газрын 1999 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан "Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын зарим ажилтанд нэмэгдэл хөлс олгох тухай журам"-д тус төвийг хамааруулсугай.

Зургаа. "Амьдрах ухаан-сургалт, үйлдвэрлэлийн тусгай төв"-д Засаг даргын Тамгын газрын Авто баазаас дуудлагын машинаар үйлчилж байхыг Нийтлэг үйлчилгээний газар /Т.Дашням /-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД

0201178

**"АМЬДРАХ УХААН" СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ТУСГАЙ ТӨВ /ОРОН ГЭРГҮЙ ТЭНЭМЭЛ ИРГЭДИЙН  
ТҮР ХОНОГЛОХ БАЙРТАЙ/ -ИЙН ДҮРЭМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. "Амьдрах ухаан- сургалт үйлдвэрлэлийн тусгай төв" / Орон гэргүй иргэдийн түр хоноглох байртай / нь / цаашид тусгай төв гэх/ орон гэргүй тэнэмэл иргэдийн талаар гаргасан хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нийслэлийн хэмжээнд эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий төрийн үйлчилгээний байгууллага мөн.

1.2. Тусгай төв нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэр, хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгон ажиллана.

1.3. Тусгай төв нь орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдэд мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгох, төлөвшүүлэх, тэдэнд нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх замаар орлогын эх үүсвэртэй болгох чиглэлээр үйл ажиллагааг эрхэлнэ.

1.4. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын хэрэгжүүлдэгч агентлаг Хөдөлмөр нийгмийн хамгааллын албаны удирдлага дор үйл ажиллагаагаа явуулж тайлагнах ба холбогдох бусад байгууллагаас мэргэжил арга зүйн туслалцаа авч ажиллана.

1.5. Тусгай төвийн бүтэц орон тооны хязгаарыг нийслэлийн Засаг дарга тогтоож, даргыг томилж чөлөөлнө.

1.6. Тусгай төв нь тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.7. Тусгай төв нь орон нутгийн төсөв болон хандив тусламж өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжигдэнэ.

**Хоёр. Тусгай төвийн үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэх үүрэг**

2.1. Тусгай төв нь Засгийн газрын 2003 оны 138 дугаар тогтоолоор батлагдсан "Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэмшүүлэх дэд хөтөлбөр" болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан нийслэлийн Засаг даргын 2003 оны 272 дугаар захирамж, бусад шийдвэрийг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

2.2. Нийслэлийн хэмжээнд бүртгэгдсэн орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэнийг түр хоноглох байранд шилжүүлэн байршуулах ажлыг дүүргүүдийн Засаг дарга болон нийслэлийн Цагдаагийн газартай тухай бүр хамтран зохион байгуулна.

2.3. орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийн дундаас гэр бүлтэй болон цаашид гэр эзэмшин амьдрах чадвартай иргэдийг гэр оронтой болгох арга хэмжээ авна.



- 2.4. Тэнэмэл амьдралтай иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээний талаар зөвөлгөө өгөх, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээнд хамруулах, тэдний үр хүүхдийг төлөвлөгөөт болон нөхөн дархлаажуулалтанд хамруулан эрүүлжүүлнэ.
- 2.5. Иргэний бүртгэлгүй, бичиг баримтгүй тэнэмэл иргэдийн иргэний бичиг баримтыг бүрдүүлж, зөрчилгүй болгох, тухайн орон нутгийн засаг захиргаанд нь тухай бүр хүлээлгэн өгнө.
- 2.6. 1990 оноос хойш хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төвүүдэд хүмүүжиж байсан, одоо граншей, орц, бусад газраар тэнүүчилж яваа 17-24 насны залуучуудыг тусгай төвд байршуулан тэдний сонирхол, авьяас чадварын дагуу тусгай төвийн мэргэжил олгох дамжаанд хамруулан мэргэжил олгох, ажлын байраар хангаж орлогын эх үүсвэртэй болгоно.
- 2.7. Тэнэмэл амьдралтай иргэдийг нийгэм, хамт олны дунд төлөвшүүлэх ажилд өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах, энэ талаар гаргасан явцаа санап санаачлагыг дэмжин ажиллана.
- 2.8. Нийслэлийн хэмжээнд буй орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийн дунд сэтгэцийн эмгэгтэй, мансуурах донтои иргэдийн судалгааг гаргаж зохих шатны эмчилгээнд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна.
- 2.9. Нийслэлийн хэмжээнд байгаа орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгож ажлын байраар хангах ажлыг Хөдөлмөр эрхлэлтийн албадтай хамтран зохион байгуулна.
- 2.10. Орон гэргүй тэнэмэл иргэдийг нийгэмшүүлэх, мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх замаар орлогын эх үүсвэртэй болгох, гэр оронтой болгох ажилд гадаад, дотоодын аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллага, иргэд, хөрөнгө оруулагчдын тусламж дэмждэгийг авах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.11. Хөдөө орон нутгаас ирсэн, нийслэлд оршин суух бүртгэлгүй, орон гэргүй, тэнэмэл иргэдийг орон нутагт нь буцаах, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээний зардлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

#### Гурав. Тусгай төвийн эрх

- 3.1. Нийслэлийн хэмжээнд байгаа орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэдийн талаархи шаардлагатай мэдээ материал, тооцоо судалгааг нийслэл дүүргийн төрийн болон төрийн бус байгууллага албан тушаалтнаар гаргуулан авна.
- 3.2. Тэнэмэл амьдралтай иргэдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг зохих журмын дагуу боловсруулж нийслэлийн Засаг даргын Тамгын газарт оруулж шийдвэрлүүлж байна.
- 3.3. Хууль тогтоомжийн хүрээнд өөрийн үйл ажиллагааны чиглэлээр гадаад дотоодын хөрөнгө оруулагчид болон хандивлагч нартай хамтран ажиллана.
- 3.4. Тусгай төвд суралцагчдын хийсэн бүтээгдхүүнийг борлуулах, олсон орлогын тодорхой хувиар ажиллагсад болон суралцагчдыг урамшуулах, сургалтын материаллаг баазаа бэхжүүлнэ.
- 3.5. Нийслэлийн Засаг даргаас шилжүүлсэн болон хууль тогтоомжийн дагуу бусад эрх

Дөрөв. Тусгай төвийн удирдлага, зохион байгуулалт

4.1. Тусгай төв нь ажлаа жил улирлаар төлөвлөж, улирал, хагас, бүтэн жилээр тайлан бичиж, төлөвлөгөөний биелэлт гаргаж Тамгын газарт хугацаанд нь ирүүлнэ.

4.2. Тусгай төвийн дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

4.3. Тусгай төвийн дарга нь батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан албан хаагчдыг томилж чөлөөлнө.

4.4. Тусгай төвийн даргын ээлжит амралт, удаан хугацааны сургалт, томилолт, чөлөөтэй үед төвийн удирдлагыг ахлах арга зүйч менежер албан ёсоор гүйцэтгэнэ.

4.5. Тусгай төвийн дарга холбогдох хууль тогтоомж, энэ дүрэм, нийслэлийн Засаг даргаас өгсөн удирдлагын дагуу төвийн ажилтнуудтай гэрээ байгуулан ажиллаж, тэдний өдөр тутмын ажлыг удирдлагаар ханган уялдуулж, цаг үеийн ажлыг шуурхай зохион байгуулна.



Нийслэлийн Засаг даргын 2003 оны

417-р захирамжийн хоёрдугаар хавсралт

"АМЬДРАХ УХААН" СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН  
ТУСГАЙ ТӨВИЙН ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН  
САНГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Албан тушаалын нэр	2003 оны 4-р улирал		2004 онд төлөвлөсөн	
		тоо	сарын цалин / төг	тоо	сарын цалин / төг
1	Төвийн захирагч	1	61900	1	61900
2	Нягтлан бодогч	1	58000	1	58000
3	Ахлах арга зүйч	1	47000	1	47000
4	Нярав, жолооч	1	45800	1	45800
5	Харуул	4	183200	4	183200
6	Тогооч	1	43600	1	43600
7	Бэлтгэгч	2	87200	2	87200
8	Бохир, халуун усны үйлчлэгч	1	43600	1	43600
9	Сувилагч	1	45800	1	45800
10	Сургалтын багш	2	110600	4	221200
11	Жижүүр	3	130800	3	130800
12	Дүн	18	857300	20	967900